


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ 2 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 963.4 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1,175.1 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 211.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээний 38.7 хувьтай тэнцэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал төлөвлөснөөс буурч сайжирсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг



Орон нутгийн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 75.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 5.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Монгол Улсын 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 35.9 хувь буюу 254.5 тэрбум төгрөгөөр өсчээ. Харин нийт зарлага 21.5 хувь буюу 207.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 18.1 хувь буюу 46.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	275.0	-130.0	458.7	-352.9	-588.7
Засгийн газрын бонд	-15.6	1,671.9	-348.3	-20.8	2,020.2
Засгийн газрын зээл	11.9	-1,189.5	101.3	-8.5	-1,290.7
Урьдчилгаа төлбөр	-12.9	0.0	0.0	-	0.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	18.6	0.0	-	18.6
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	175.8	0.0	-	175.8
НИЙТ ДҮН	258.5	547.0	211.7	38.7	335.2

Эх сурвалж: Сангийн яам

2017 оны эхний 2 сард гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 19.8 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 673.8 тэрбум төгрөгийг тус тус төлж, 111.4 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авчээ. Засгийн газрын 69.8 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 255.7 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод бондыг тус тус арилжаалсан байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 963.4 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 35.9 хувиар буюу 254.5 тэрбум төгрөгөөр өсч, орлогын төлөвлөгөө 100.0 хувь биелсэн байна.

2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 32.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн боловч орон нутгийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 13.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн хэмжээнээс давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 238.3 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 56.3 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 51.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Нэгдсэн төсвийн орлогын 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 2. /тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,030.8	1,034.0	782.2	753.5	363.2	365.5	290.9	304.5
ИРЭЭДҮЙН ӨВ САН	65.7	58.2	65.7	58.2	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	1.7	12.5	1.7	12.5	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	963.4	963.4	714.9	682.9	363.2	365.5	290.9	304.5
ТАТВАРЫН ОРЛОГО	809.6	819.9	537.3	514.5	115.5	122.8	193.0	206.6
- Орлогын албан татвар	246.0	251.5	164.6	165.1	81.4	86.4	0.0	0.0
- Нийгмийн даатгалын орлого	156.8	182.6	0.0	0.0	0.0	0.0	193.0	206.6
- Хөрөнгийн албан татвар	11.8	11.2	0.0	0.0	11.8	11.2	0.0	0.0
- Нэмэгдсэн өртгийн албан татвар	169.9	174.4	169.9	174.4	0.0	0.0	0.0	0.0
- Онцгой албан татвар	92.1	66.7	92.1	66.7	0.0	0.0	0.0	0.0
- Тусгай зориулалтын	1.6	1.8	1.6	1.8	0.0	0.0	0.0	0.0
- Гадаад худалдааны орлого	54.1	54.0	54.1	54.0	0.0	0.0	0.0	0.0
- Бусад татвар	77.4	77.7	55.0	52.5	22.3	25.2	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153.9	143.5	177.6	168.3	247.7	242.7	97.9	97.9
- Нийтлэг татварын бус орлого	135.6	136.8	117.4	122.8	18.2	14.0	0.0	0.0
- Хөрөнгийн орлого	0.1	0.1	0.0	0.0	0.1	0.1	0.0	0.0
- Тусламжийн орлого	18.2	6.5	48.3	37.5	0.5	0.0	97.9	97.9
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	11.9	8.0	228.8	228.6	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 85.0 хувь нь татварын орлого, 15.0 хувь нь татварын бус орлого эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 30.7 хувь буюу 192.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 76.2 хувь буюу 62.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Татварын орлого 819.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн орлого 1.3 хувь буюу 10.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 30.7 хувийг орлогын албан татвар, 22.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.4 хувийг хөрөнгийн албан татвар, 21.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.1 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 6.6 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.5 хувийг бусад татвар бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/



Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийгмийн даатгалын орлого 16.5 хувь /25.8 тэрбум.төг/, орлогын албан татвар 2.3 хувь /5.6 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 2.6 хувь /4.5 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 18.4 хувь /0.3 тэрбум.төг/, бусад татвар 0.4 хувь /0.3 тэрбум.төг/-иар тус тус давж биелжээ. Харин онцгой албан татвар 27.6 хувь /25.4 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 5.8 хувь /0.7 тэрбум.төг/-иар тус тус дутуу төвлөрсөн байна.

2016 оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 192.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үеэс онцгой албан татвар 20.0 тэрбум төгрөг (23.1%)–өөр буурсан хэдий ч орлогын албан татвар 143.6 тэрбум төгрөг (133.1%), бусад татвар 23.3 тэрбум төгрөг (42.9%), гадаад үйл ажиллагааны орлого 21.5 тэрбум төгрөг (66.1%), нэмэгдсэн өртгийн албан татвар 13.7 тэрбум төгрөг (8.6%), нийгмийн даатгалын орлого 7.2 тэрбум төгрөг (4.1%), хөрөнгийн албан татвар 2.6 тэрбум төгрөг (30.1%) болон тусгай зориулалтын орлого 0.5 тэрбум төгрөг (42.0%)–өөр тус тус өссөн байна.

Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	76.5	5,347.8	0.0	5,347.8	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	625.1	553.3	1,176.9	-623.6	212.7
Монгол Улсын Их Хурлын дарга	72.1	428.3	530.3	-102.0	123.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	72.1	428.3	530.3	-102.0	123.8
Монгол Улсын Ерөнхий аудитор	0.0	86.5	0.0	86.5	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	86.5	0.0	86.5	-
Монгол Улсын Ерөнхий сайд	423.2	778.0	1,008.6	-230.6	129.6
Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	0.0	200.0	0.0	200.0	-
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	0.0	0.0	502.3	-502.3	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	423.2	578.0	506.3	71.7	87.6
Монгол Улсын Шадар сайд	1,486.8	1,601.3	755.0	846.3	47.2
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	129.6	375.4	470.4	-95.0	125.3
Стандарт, хэмжил зүйн газар	0.0	294.1	0.0	294.1	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	883.6	0.0	883.6	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,357.1	48.2	284.6	-236.4	590.8
Хууль зүй, дотоод хэргийн сайд	9,629.70	6,191.5	5,266.4	925.2	85.1
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	7,611.20	2,650.0	2,502.5	147.5	94.4
Цагдаагийн ерөнхий газар	10.20	581.3	405.5	175.7	69.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	159.00	0.0	0.0	0.0	-
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	1,849.30	328.0	186.1	141.9	56.7
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,849.3	2,632.3	2,172.3	460.0	82.5
Гадаад харилцааны сайд	1,486.80	1,992.9	3,177.7	-1,184.8	159.5
Дипломат төлөөлөгчийн газрууд	1,427.70	1,734.6	3,159.3	-1,424.7	182.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	59.10	258.3	18.4	239.9	7.1
Зам, тээврийн хөгжлийн сайд	18,439.0	23,896.1	11,852.6	12,043.5	49.6
Иргэний нисэхийн ерөнхий газар	18,000.0	23,058.7	10,392.9	12,665.8	45.1
Зам, тээврийн хөгжлийн яам	20.0	0.0	0.0	0.0	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	519.7	609.1	-89.4	117.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	419.0	317.7	850.7	-533.0	267.8
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	26,406.0	38,503.2	42,660.7	-4,157.5	110.8
Ашигт малтмал, газрын тосны газар	25,968.5	37,474.9	41,522.0	-4,047.1	110.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	528.3	0.0	528.3	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	437.5	500.0	1,138.7	-638.7	227.7
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,370.6	12,414.9	18,819.7	-6,404.7	151.6
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	24.0	0.0	24.0	-
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	63.0	87.9	80.1	7.8	91.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	2,165.3	0.0	2,165.3	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,307.6	10,137.7	18,739.6	-8,601.9	184.8

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1,652.9	30,408.4	36,909.8	-6,501.3	121.4
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	1,131.9	1,065.7	1,748.4	-682.7	164.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	520.9	29,342.7	35,161.4	-5,818.7	119.8
Эрүүл мэндийн сайд	25,447.0	36,086.6	28,890.9	7,195.7	80.1
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого	21,662.6	29,507.0	25,074.1	4,432.8	85.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	2,472.8	7.8	2,465.0	0.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,784.5	4,106.8	3,808.9	297.9	92.7
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	127.9	3,342.5	3,585.8	-243.3	107.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	35.7	3,319.6	3,564.1	-244.5	107.4
Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого	92.2	22.9	21.7	1.2	94.8
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	19.8	160.0	7.0	153.0	4.4
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	136.2	0.0	136.2	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	19.8	23.8	7.0	16.7	29.6
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	477.9	746.4	1,492.2	-745.8	199.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0	308.0	0.0	308.0	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	477.9	438.4	1,492.2	-1,053.8	340.4
Барилга, хот байгуулалтын сайд	0.0	273.5	74.7	198.8	27.3
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	0.0	194.0	0.0	194.0	-
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	79.5	74.7	4.8	93.9
Батлан хамгаалахын сайд	5,655.7	6,425.7	1,795.0	-4,630.7	27.9
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	840.0	669.3	669.3	0.0	100.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,815.7	5,756.4	1,125.7	4,630.7	19.6
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	46.2	10.0	2.0	8.0	20.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	46.2	10.0	2.0	8.0	20.0
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	34.3	137.1	123.5	13.6	90.1
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	34.3	137.1	123.5	13.6	90.1
Үндэсний статистикийн хорооны дарга	0.0	91.9	0.3	91.6	0.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	0.0	90.9	0.0	90.9	-
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	1.0	0.3	0.7	25.2

Эх сурвалж: Сангийн яам

3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 1,510.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 77.8 хувийг ашиглаж, 335.3 тэрбум төгрөгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,510.4	1,175.1	1,186.7	975.0	415.6	290.0	313.5	299.5
НИЙТ ЗАРЛАГА	1,466.5	1,140.0	1,148.3	940.7	410.1	289.4	313.5	299.5
УРСГАЛ ЗАРЛАГА	1,230.9	1,016.3	967.4	826.2	355.5	280.0	313.5	299.5
Бараа, үйлчилгээний зардал	549.9	422.4	325.1	241.2	247.7	202.1	3.6	3.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	159.3	148.6	159.3	148.6	0.0	0.0	0.0	0.0
Татаас	66.0	46.8	144.5	129.9	12.5	10.8	6.9	4.0
Урсгал шилжүүлэг	455.6	398.5	338.5	306.6	95.3	67.1	303.0	292.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235.6	123.7	180.9	114.4	54.7	9.3	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	43.9	35.1	38.4	34.4	5.5	0.7	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-547.0	-211.7	-471.9	-292.2	-52.4	75.5	-22.6	5.0

Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад улсын төсвийн зарлага 211.7 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 125.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 14.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

2016 оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт зардал 305.4 тэрбум, орон нутгийн төсөв 7.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 34.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оноос 21.5 хувь буюу 207.8 тэрбум төгрөгөөр өсөхөд зээлийн үйлчилгээний төлбөр 63.7 тэрбум, урсгал шилжүүлэг 42.0 тэрбум, татаас 39.6 тэрбум, хөрөнгийн зардал 34.6 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 31.0 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин бараа үйлчилгээний зардал 0.7 хувь буюу 3.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл

/Зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

Ангилал	ӨО-ны мөн үеийн	2017 оны 2 дугаар сар			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	967.3	1,510.4	1,175.1	77.8%	335.3
НИЙТ ЗАРЛАГА	963.2	1,466.5	1,140.0	77.7%	326.5
УРСГАЛ ЗАРДАЛ	874.1	1,230.9	1,016.3	82.6%	214.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425.5	549.9	422.4	76.8%	127.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269.3	293.4	278.8	95.0%	14.7
Үндсэн цалин	244.1	243.4	240.6	98.8%	2.8
Нэмэгдэл	12.5	32.7	24.6	75.4%	8.0
Унаа хоолны хөнгөлөлт	5.2	6.9	5.9	86.1%	1.0

Урамшуулал	0.8	2.5	1.0	39.4%	1.5
Гэрээт ажлын хөлс	6.7	8.0	6.6	83.1%	1.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43.2	55.3	45.9	83.0%	9.4
Гэрэл, цахилгаан	7.4	8.9	7.9	89.5%	0.9
Түлш, халаалт	30.2	37.9	31.4	82.7%	6.5
Цэвэр, бохир ус	3.0	4.6	3.1	66.9%	1.5
Байрны түрээс	2.6	3.9	3.5	89.3%	0.4
Хангамж, бараа материалын зардал	14.2	19.1	14.0	73.6%	5.0
Бичиг хэргэг	1.2	1.7	1.2	68.3%	0.6
Тээвэр, шатахуун	5.4	6.6	5.5	82.5%	1.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.7	2.1	1.5	71.8%	0.6
Ном, хэвлэл	0.3	0.8	0.1	16.6%	0.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4.8	6.4	4.8	75.0%	1.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.9	1.4	0.9	68.5%	0.4
Нормативт зардал	28.2	43.0	28.5	66.2%	14.5
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10.9	18.4	12.0	64.9%	6.5
Хоол, хүнс	14.9	20.4	14.6	71.8%	5.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.4	4.2	1.9	45.2%	2.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2.4	7.8	4.4	57.3%	3.3
Багаж, техник, хэрэгсэл	0.4	3.2	2.1	63.3%	1.2
Тавилга	0.4	0.6	0.4	62.7%	0.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.1	0.2	0.1	28.0%	0.1
Урсгал засвар	1.5	3.7	2.0	52.8%	1.8
Томилолт, зочны зардал	2.1	3.7	1.9	50.3%	1.9
Гадаад албан томилолт	0.8	1.2	0.5	45.4%	0.7
Дотоод албан томилолт	1.2	2.3	1.1	49.7%	1.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	0.2	0.2	0.2	80.1%	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40.4	70.7	23.1	32.6%	47.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22.9	64.1	19.2	30.0%	44.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.2	0.6	0.3	42.7%	0.3
Даатгалын үйлчилгээ	1.2	2.6	2.0	74.9%	0.7
Тээврийн хэрэгслийн татвар	0.0	0.1	0.0	15.9%	0.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.0	0.0	16.4%	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.5	1.2	0.6	52.7%	0.6
Газрын төлбөр	0.1	0.3	0.1	21.5%	0.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.0	0.3	0.2	74.3%	0.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.5	1.5	0.7	46.5%	0.8
Бараа үйлчилгээний бусад зардал	25.7	57.0	25.9	45.5%	31.1
Бараа үйлчилгээний бусад зардал	22.0	49.1	20.7	42.1%	28.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3.8	7.8	5.2	66.7%	2.6
ХҮҮ	84.9	159.3	148.6	93.3%	10.7
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	31.1	41.5	40.4	97.4%	1.1
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	53.8	117.8	108.2	91.8%	9.6

TATAAC	7.2	66.0	46.8	70.9%	19.2
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	0.7	3.8	1.2	30.6%	2.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	6.5	62.2	45.6	73.4%	16.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	356.5	455.6	398.5	87.5%	57.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6.2	19.0	2.9	15.1%	16.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	5.9	17.7	2.8	15.7%	14.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.3	1.3	0.1	6.5%	1.2
Бусад урсгал шилжүүлэг	350.3	436.6	395.6	90.6%	41.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	231.0	261.5	260.6	99.7%	0.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	96.9	101.2	92.9	91.8%	8.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.4	1.1	0.6	56.4%	0.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8.4	36.3	17.8	49.0%	18.5
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	0.0%	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12.1	18.8	9.1	48.6%	9.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэ	1.1	16.5	13.8	83.9%	2.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.4	1.3	0.7	55.1%	0.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89.1	235.6	123.7	52.5%	111.9
Барилга байгууламж	18.9	109.1	101.2	92.8%	7.8
Их засвар	27.2	6.9	0.8	11.0%	6.1
Тоног төхөөрөмж	5.4	12.2	1.7	13.5%	10.6
Бусад хөрөнгө	4.1	30.6	2.0	6.4%	28.6
Стратегийн нөөц хөрөнгө	0.0	9.9	8.5	85.7%	1.4
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	33.5	67.0	9.7	14.4%	57.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4.1	43.9	35.1	79.8%	8.9
Эргэж төлөгдөх зээл	4.1	25.9	20.6	79.5%	5.3
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.0	18.0	14.5	80.3%	3.6


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 86.5 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.9 пунктээр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 86.5 хувь буюу 1,016.3 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 41.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 15.0 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 5.0 хувийг татаас, 39.0 хувийг урсгал шилжүүлэгт ногдож байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 142.2 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд зээлийн үйлчилгээний

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



төлбөр 63.7 тэрбум, татаас 39.6 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл 31.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах эрхийг баталсан бөгөөд улсын төсвийн 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 207.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Улсын төсвийн нийт зарлагын 21.9 хувийг Сангийн сайдын багц, 19.9 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багц, 8.6 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 19.1 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.2 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 2.6 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, 9.8 хувийг Зам тээврийн хөгжлийн сайд, 4.6 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, үлдэх 7.3 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөгөөр/

Төсвийн ерөнхийлөн захирагч	2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	884.5	710.2	174.2	80.3
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	4,577.3	3,997.4	579.9	87.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	17,740.2	10,620.2	7,120.1	59.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	3,716.7	1,070.2	2,646.5	28.8
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	11,034.4	10,634.8	399.7	96.4
САНГИЙН САЙД	296,052.5	206,073.0	89,979.5	69.6
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	31,621.7	24,051.6	7,570.1	76.1
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	106,794.6	80,785.6	26,009.0	75.6
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	337.4	231.7	105.7	68.7
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	770.8	560.6	210.2	72.7
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	8,249.4	7,142.7	1,106.7	86.6
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4,805.7	4,277.6	528.1	89.0
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	374.4	264.1	110.3	70.5
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,707.5	1,299.1	408.5	76.1
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1,116.2	829.9	286.3	74.3
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	363.8	304.4	59.3	83.7
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	88.2	86.5	1.7	98.1
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	156.1	141.6	14.5	90.7
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	19,625.3	14,473.7	5,151.7	73.7
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	3,124.1	121.7	3,002.4	3.9
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	145.0	120.4	24.5	83.1
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,060.0	1,201.0	859.0	58.3
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,703.1	5,655.3	6,047.8	48.3
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	68,171.4	58,750.5	9,420.9	86.2
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	5,121.1	2,298.5	2,822.6	44.9
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	211,972.2	187,525.6	24,446.6	88.5

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	55,581.2	92,485.1	(36,904.0)	166.4
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,883.2	1,130.1	2,753.1	29.1
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	58,208.3	43,069.0	15,139.3	74.0
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	6,184.6	1,121.2	5,063.4	18.1
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛТЫН САЙД	212,168.8	179,631.9	32,537.0	-
НИЙТ ЗАРДАЛ	1,148,339.6	940,665.0	207,674.6	81.9

Эх сурвалж: Сангийн яам

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ

2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр Чингис бонд болон Хөгжлийн банкны эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэхээр төсөвт тусгагдсан төсөл арга хэмжээнд 9.8 тэрбум төгрөг зарцуулж, 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл

Хүснэгт 7.

/сая төгрөгөөр/

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих	2017 оны 2 сар /өссөн дүнгээр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Авто зам	151,727.9	16,100.2	1,455.4	1,455.4	-	100.0
Гудамж төсөл	79,125.9	11,804.7	2,060.3	1,970.8	89.5	95.7
Инженерийн дэд бүтэц	136,070.2	22,629.2	2,137.6	2,093.2	44.4	97.9
Гэр хорооллын дэд бүтэц	78,195.4	8,167.3	336.6	336.6	-	100.0
Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил	2,925.8	126.7				
Эгийн голын усан цахилгаан станц	14,041.1	14,041.1				
Амгалан дулааны станц	3,988.3	1,010.6				
2016 оны төсвийн тухай хуулийн дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх бусад төслүүд	546,877.1	98,915.1	3,927.4	3,927.3	0.1	100.0
НИЙТ ДҮН	1,012,951.7	172,794.9	9,917.3	9,783.3	134.0	98.6

Эх сурвалж: Хөгжлийн банк

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 8.2 тэрбум төгрөг зарцуулж, 34.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 оны эхний 2 сард хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 23.7 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 8.2 тэрбум төгрөг зарцуулсан нь төлөвлөсөн хэмжээнээс 15.5 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

График 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөгөөр/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл,
/төсвийн ерөнхийлөн захирагчаар/

Хүснэгт 8.

/сая төгрөгөөр/


ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ТӨСӨВ	2017 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
			Төлөв.	Гүйцэт.	Зөрүү	Хувь
УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1,688.0	1,688.0	-	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	18,023.4	5,228.7	1,042.8	1,042.8	0.0	100.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	15,348.3	3,506.1	372.1	-	372.1	-
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2,593.5	824.3	-	-	-	-
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	5,160.0	700.0	-	-	-	-
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	67,170.2	27,303.2	1,435.8	1,432.0	3.8	99.7
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	23,946.7	7,391.1	633.4	-	633.4	-
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	30,296.8	2,693.1	-	-	-	-
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	76,579.4	14,694.0	2,767.8	1,847.6	920.1	66.8
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	398,908.1	96,307.0	11,112.1	3,060.0	8,052.2	27.5
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	167,133.7	29,438.5	4,088.7	570.6	3,518.1	14.0
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	32,066.3	7,113.0	-	-	-	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	174,407.1	35,918.3	1,700.0	-	1,700.0	-
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	56,191.8	16,909.8	-	-	-	-
АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	1,031.4	851.4	425.7	213.1	212.6	50.1
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	952.7	88.3	88.3	-	88.3	-
НИЙТ ДҮН	1,071,497.4	250,654.7	23,666.7	8,166.1	15,500.6	34.5

Эх сурвалж: Сангийн яам

5. Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого:

График 7. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын санд 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр нийт 304.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 4.7 хувиар буюу 13.6 тэрбум төгрөгөөр илүү давж биелж, орлогын гүйцэтгэл 104.7 хувьтай байна.


Нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 51.9 тэрбум төгрөг буюу 20.5 хувиар өссөн байна. Тус санд улсын төсвөөс 97.9 тэрбум төгрөгийн татаасыг олгожээ.

Нийгмийн даатгалын таван санд 2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэл орлого 206.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг дараахь байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын санд 123.5 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын санд 14.5 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 10.7 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын санд 5.7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 29.3 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага:


График 8. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /тэрбум төгрөгөөр/



2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн нийт зардалд 313.5 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бусад зардалд нийт 299.5 тэрбум төгрөгийг зарцуулснаар 95.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн нийт зардал 34.6 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 299.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 34.6 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 22.0 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 4.7 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 2.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

График 9. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /хувиар/



2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 231.0 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 13.8 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон

тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 6.9 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид болон бусад зардалд 7.0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэгийн тусламж, үйлчилгээ, рашаан сувилал, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад зардалд 37.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний эмийн зардалд 31.0 тэрбум, рашаан сувиллын зардалд 0.9 тэрбум, эмийн үнийн хөнгөлөлтөд 4.0 тэрбум төгрөг тус тус зарцуулагджээ.

6. Орон нутгийн төсөв


Орон нутгийн төсвийн зарлага 125.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Орон нутгийн төсвийн орлого 365.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 0.6 хувь буюу 2.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Харин нийт зарлага 290.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 30.2 хувиар буюу 125.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 18.2 хувиар буюу 56.3 тэрбум төгрөг, мөн нийт зарлага 2.5 хувиар буюу 7.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 37.5 хувийг орон нутгийн төсвийн орлого, 8.4 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 52.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 1.3 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 30.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

График 10. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Мөн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 192.9 тэрбум төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр аймгуудад олгосон байна.

Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 9.

/сая төгрөгөөр/

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	2,779.3	2,779.3	100.0	6,744.1	6,744.1	100.0	190.7	183.3	96.1
Баян-Өлгий	2,399.5	2,399.5	100.0	9,401.1	9,401.1	100.0	170.9	170.9	100.0
Баянхонгор	2,595.2	2,595.2	100.0	7,470.2	7,470.2	100.0	207.5	188.4	90.8
Булган	0.0	0.0	0.0	5,905.7	5,905.7	100.0	155.2	139.8	90.1
Говьсүмбэр	0.0	0.0	0.0	1,610.2	1,610.2	100.0	100.3	75.9	75.6
Говь-Алтай	1,913.0	1,913.0	100.0	6,632.9	6,632.9	100.0	197.3	165.0	83.7
Дархан-Уул	0.0	0.0	0.0	6,154.2	6,154.2	100.0	158.0	158.0	100.0
Дорноговь	0.0	0.0	0.0	5,381.5	5,381.5	100.0	176.3	155.7	88.3
Дорнод	584.9	584.9	100.0	5,977.1	5,977.1	100.0	187.7	170.4	90.8
Дундговь	1,339.3	1,339.3	100.0	4,276.1	4,276.1	100.0	156.6	130.6	83.4
Завхан	2,190.4	2,190.4	100.0	6,083.6	6,083.6	100.0	175.8	159.2	90.5
Орхон	0.0	0.0	0.0	5,334.8	5,334.8	100.0	174.4	174.4	100.0
Өвөрхангай	2,672.3	2,672.3	100.0	7,818.8	7,818.8	100.0	209.7	208.8	99.6
Өмнөговь	0.0	0.0	0.0	5,019.1	5,019.1	100.0	191.3	163.4	85.4
Сүхбаатар	1,190.4	1,190.4	100.0	5,209.7	5,209.7	100.0	165.0	144.3	87.5
Сэлэнгэ	800.0	800.0	100.0	7,840.8	7,840.8	100.0	178.5	178.5	100.0
Төв	1,773.3	1,773.3	100.0	7,331.8	7,331.8	100.0	173.5	170.6	98.3
Увс	2,591.9	2,591.9	100.0	6,820.1	6,820.1	100.0	172.9	161.1	93.2
Улаанбаатар	0.0	0.0	0.0	58,854.5	58,854.5	100.0	1,364.3	1,364.3	100.0
Ховд	1,808.2	1,808.2	100.0	6,575.7	6,575.7	100.0	187.5	174.3	92.9
Хөвсгөл	4,204.2	4,204.2	100.0	9,550.0	9,550.0	100.0	219.8	219.8	100.0
Хэнтий	1,974.6	1,974.6	100.0	6,940.5	6,940.5	100.0	177.4	161.2	90.8
ДҮН	30,816.5	30,816.5	100.0	192,932.5	192,932.5	100.0	5,090.7	4,818.0	94.6

Эх сурвалж: Сангийн Яам

2017 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр аймгуудийн орон нутгийн хөгжлийн санд 4.8 тэрбум төгрөг байгаа нь төлөвлөсөн хэмжээнээс 5.4 хувь буюу 272.7 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА